НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Багануурын дулааны станц ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2024/02/НА-СТА-ОНА

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2024 он | Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Н.Баттогоо<br>Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 03. 15 № 506

танай ____________-ны №____________-т

БАГАНУУРЫН ДУЛААНЫ
СТАНЦ ТӨХК-НИЙ ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Б.АРИУН-ЭРДЭНЭ
ТАНАА

# АУДИТЫН ДҮГНЭЛТ

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Багануур дулааны станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Багануур дулааны станц ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 143.2 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох журамтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон хэсэг

Багануур дулааны станц ТӨХК нь 2023 онд орлогыг татварын цахим тайлантай тулгахад орлого болон татварыг зөрүүтэй тайлагнасан, хугацаа хэтэрсэн авлага нэмэгдсэн, үйлдвэрийн үйл ажиллагаанд зарцуулагдсан материалын норм норматив тооцоож мөрдөөгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн зэрэг асуудлууд байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Эрчим хүчний сайдын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/266 дугаар тушаал, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 28 дугаар тогтоолоор тус тус шинэчлэн баталсан компанийн 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний 13 үзүүлэлтүүдээс 10 үзүүлэлтийг хангаж, 77.0 хувиар биелүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **507,699,547.42** | **989,802,845.54** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **28,073,676.03** | **55,640,218.84** |
| **31100** | **Кассад байгаа бэлэн мөнгө** | **4,329,673.46** | **-** |
| 31110 | Төгрөг | 4,329,673.46 | - |
| **31200** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **23,744,002.57** | **55,640,218.84** |
| **31210** | **Төгрөг** | **23,744,002.57** | **55,640,218.84** |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 23,744,002.57 | 55,640,218.84 |
| **33** | **АВЛАГА** | **235,272,647.70** | **603,025,144.40** |
| 33401 | Дансны авлага /ТӨХК/ | 191,006,647.70 | 594,055,769.68 |
| **33500** | **Бусад авлага** | **44,266,000.00** | **8,969,374.72** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 44,266,000.00 | 8,969,374.72 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **-** | **44,195,454.52** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 44,195,454.52 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **244,353,223.69** | **286,942,027.78** |
| **35100** | **Түүхий эд материал** | **86,460,000.25** | **83,886,668.19** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 86,460,000.25 | 83,886,668.19 |
| **35400** | **Хангамжийн материал** | **157,893,223.44** | **203,055,359.59** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 9,619,932.30 | 18,709,148.24 |
| 35420 | Аж ахуйн материал | 28,188,952.63 | 18,709,148.24 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 110,267,820.78 | 116,165,664.69 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,635,812.85 | 3,649,809.64 |
| 35450 | Барилгын засварын материал | 4,180,704.88 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | - | 45,821,588.78 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,939,566,772.43** | **8,522,236,977.13** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **8,939,566,772.43** | **8,522,236,977.13** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **7,677,666,307.00** | **7,050,921,590.28** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 7,261,444,315.90 | 7,224,984,213.27 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (3,346,072,166.09) | (3,816,759,231.77) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 931,905,581.22 | 772,952,163.04 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (541,737,394.23) | (429,418,723.51) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 9,893,133,696.70 | 9,235,735,245.82 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (6,643,116,112.86) | (6,054,603,844.69) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 68,859,957.00 | 55,375,600.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (46,143,529.87) | (37,791,215.25) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 264,218,333.56 | 300,620,697.20 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (164,826,374.33) | (200,173,313.83) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **1,059,273,600.00** | **1,059,273,600.00** |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,059,273,600.00 | 1,059,273,600.00 |
| **39400** | **Бусад хөрөнгө /ТӨХК/** | **202,626,865.43** | **412,041,786.85** |
| 39403 | Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨХК/ | 202,626,865.43 | 150,226,372.32 |
| 39405 | Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨХК/ | - | 261,815,414.53 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **9,447,266,319.85** | **9,512,039,822.67** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,966,620,465.02** | **6,165,878,686.12** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **3,966,620,465.02** | **6,165,878,686.12** |
| **41300** | **Өглөг** | **3,966,620,465.02** | **5,875,680,504.13** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 140,900,622.72 |
| **41360** | **Бусад өглөг** | **3,966,620,465.02** | **5,734,779,881.41** |
| 41363 | Татварын өглөг /ТӨХК/ | 914,292,114.98 | 859,738,453.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 41364 | НДШ-ийн өглөг /ТӨХК/ | - | 110,881,244.65 |
| 41366 | Дансны өглөг /ТӨХК/ | 3,052,328,350.04 | 4,764,160,183.26 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | **-** | **290,198,181.99** |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | - | 290,198,181.99 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,480,645,854.83** | **3,346,161,136.55** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **5,480,645,854.83** | **3,346,161,136.55** |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨХК/ | 14,149,242,636.31 | 14,149,242,636.31 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨХК/ | 37,552,000.00 | 121,507,000.00 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(12,380,261,408.80)** | **(14,598,701,127.08)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (9,835,965,077.89) | (12,380,261,408.81) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (2,544,296,330.91) | (2,218,439,718.27) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 3,674,112,627.32 | 3,674,112,627.32 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **9,447,266,319.85** | **9,512,039,822.67** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮИЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **(449,691,759.48)** | **(1,152,982,495.72)** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **(449,691,759.48)** | **(1,152,982,495.72)** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **(449,691,759.48)** | **(1,152,982,495.72)** |
| 120005 | Түрээсийн орлого | 6,368,640.00 | 6,366,720.00 |
| 120009 | Бусад орлого | 1,513,638,649.94 | 2,305,720,352.55 |
| 120010 | Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨХК/ | 6,018,806,815.96 | 8,063,299,083.18 |
| **120011** | **Борлуулалтын өртөг /ТӨХК/** | **7,988,505,865.38** | **11,528,368,651.45** |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,094,604,571.43** | **1,065,457,222.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,094,604,571.43** | **1,065,457,222.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,094,604,571.43** | **1,065,457,222.55** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **533,975,045.50** | **1,065,457,222.55** |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨХК/ | 365,905,586.92 | 369,760,846.33 |
| 210812 | Санхүүгийн зардал /ТӨХК/ | 37,692,800.08 | 8,826,018.73 |
| 210813 | Бусад зардал /ТӨХК/ | 262,264,814.93 | 634,461,012.39 |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨХК/ | (131,888,156.43) | 52,409,345.10 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,560,629,525.93** | **-** |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,560,629,525.93 | - |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **(2,544,296,330.91)** | **(2,218,439,718.27)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **(2,544,296,330.91)** | **(2,218,439,718.27)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2022 оны 1-р сарын 31-ны үлдэгдэл** | **14,149,242,636.31** | **3,674,112,627.32** | **(9,835,965,077.89)** | **7,987,390,185.74** |
| 2 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **14,149,242,636.31** | **3,674,112,627.32** | **(9,835,965,077.89)** | **7,987,390,185.74** |
| 3 | **Өмчид гарсан өөрчлөлт** | **37,552,000.00** | **-** | **-** | **37,552,000.00** |
| 4 | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **(2,544,296,330.91)** | **(2,544,296,330.91)** |
| 5 | **2022 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл** | **14,186,794,636.31** | **3,674,112,627.32** | **(12,380,261,408.80)** | **5,480,645,854.83** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **6** | **2023 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл** | **14,186,794,636.31** | **3,674,112,627.32** | **(12,380,261,408.80)** | **5,480,645,854.83** |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (0.01) | (0.01) |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 14,186,794,636.31 | 3,674,112,627.32 | (12,380,261,408.81) | 5,480,645,854.82 |
| 9 | Өмчид гарсан өөрчлөлт | 83,955,000.00 | - | - | 83,955,000.00 |
| 10 | Тайлант үеийн үр дүн | - | - | (2,218,439,718.27) | (2,218,439,718.27) |
| **11** | **2023 оны 6-р сарын 30-ны үлдэгдэл** | **14,270,749,636.31** | **3,674,112,627.32** | **(14,598,701,127.08)** | **3,346,161,136.55** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **5,943,898,821.16** | **7,638,692,883.67** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,493,898,821.16** | **5,343,692,883.67** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **4,493,898,821.16** | **5,343,692,883.67** |
| 120009 | Бусад орлого | 51,140,569.40 | 115,645,229.56 |
| 120013 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨХК/ | 4,442,758,251.76 | 5,228,047,654.11 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,450,000,000.00** | **2,295,000,000.00** |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **1,450,000,000.00** | **2,295,000,000.00** |
| 133004 | Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт | 1,450,000,000.00 | 2,295,000,000.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,023,967,231.93** | **7,280,159,540.86** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,023,967,231.93** | **7,280,159,540.86** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,023,967,231.93** | **7,280,159,540.86** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,331,748,849.28** | **2.929.300.557,10** |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨХК/ | 2,331,748,849.28 | 2.929.300.557,10 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **545,675,046.99** | **997,798,258.91** |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨХК/ | 545,675,046.99 | 997,798,258.91 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **706,324,035.33** | **494,000,000.00** |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨХК/ | 706,324,035.33 | 494,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **721,193,861.90** | **1,437,426,764.75** |
| 210409 | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨХК/ | 320,331,779.46 | 739,882,497.80 |
| 210410 | Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨХК/ | 400,862,082.44 | 697,544,266.95 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **719,025,438.43** | **1,727,937,366.06** |
| 210815 | Хүүгийн төлбөр төлсөн /ТӨХК/ | 17,603,420.20 | - |
| 210816 | Татварын байгууллагад төлсөн /ТӨХК/ | 613,035,148.33 | 755,658,435.53 |
| 210818 | Бусад мөнгөн зарлага /ТӨХК/ | 88,386,869.90 | 665,975,524.57 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **919,931,589.23** | **358,533,342.81** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **498,853,596.40** | **330,966,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **498,853,596.40** | **330,966,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **498,853,596.40** | **330,966,800.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 498,853,596.40 | 330,966,800.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(498,853,596.40)** | **(330,966,800.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **(400,000,000.00)** | **-** |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **400,000,000.00** | **-** |
| 250002 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө | 400,000,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **21,077,992.83** | **27,566,542.81** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 6,995,683.20 | 28,073,676.03 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 28,073,676.03 | 55,640,218.84 |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */сая төгрөгөөр/*

| № | Техник, эдийн засгийн үзүүлэлтүүд | | Хэмжих нэгж | 2022 оны гүйцэтгэл | 2023 оны гүйцэтгэл | | Өөрчлөлт | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Төлөв-лөгөө | Гүйцэт-гэл | өмнөх оноос | | төлөвлөгөөнөөс | |
| | | | | | | | дүн | хувь | дүн | хувь |
| | | | x | 1 | 2 | 3 | 4=3-1 | 5=4/1 | 6=3-2 | 7=6/2 |
| 1 | Боловсруулсан | ЦЭХ | сая.кВт.ц | | | | - | - | - | - |
| | | ДЭХ | мян.Гкал | 174.1 | 163.1 | 178.5 | 4.4 | 103% | 15.4 | 109% |
| | Дотоод хэрэгцээний дулаан эрчим хүчний зарцуулалт | хувиар | хувь | 0.0 | 0.0 | 0.0 | (0.0) | 99% | (0.0) | 80% |
| | | биетээр | мян.Гкал | 3.7 | 4.3 | 3.8 | 0.1 | 102% | (0.5) | 88% |
| | Эрчим хүч түгээлт | ЦЭХ | сая.кВт.ц | | | | - | 0% | - | 0.0 |
| | | ДЭХ | мян.Гкал | 170.4 | 158.8 | 174.7 | 4.4 | 103% | 16.0 | 110% |
| 2 | **Нийт орлого** | | **сая.төг** | **7,538.8** | **9,773.3** | **10,375.4** | 2,836.6 | 138% | 602.1 | 106% |
| | Үүнээс: | Борлуулалтын орлого | сая.төг | 6,018.8 | 7,867.8 | 8,063.3 | 2,044.5 | 134% | 195.5 | 102% |
| | | Үйл ажиллагааны бус орлого | сая.төг | 201.8 | 87.3 | 225.7 | 23.9 | 112% | 138.4 | 259% |
| | | Санхүүжилт (татаас) | сая.төг | 1,318.2 | 1,818.2 | 2,086.4 | 768.2 | 158% | 268.2 | 115% |
| 3 | **Нийт зардал** | | **сая.төг** | **10,215.0** | **12,474.0** | **12,541.4** | **2,337.2** | **123%** | **67.4** | **101%** |
| | Үүнээс: | Үйл ажиллагааны зардал | сая.төг | 10,145.2 | 12,429.1 | 12,475.4 | 2,328.3 | 123% | 46.3 | 100% |
| | | Үйл ажиллагааны бус зардал | сая.төг | 69.8 | 44.9 | 66.0 | 9.0 | 116% | 21.1 | 147% |
| 4 | Татварын өмнөх ашиг/алдагдал | | сая.төг | **(2,676.2)** | **(2,700.8)** | **(2,166.0)** | **499.3** | **81%** | **534.7** | **80%** |
| 5 | **Татварын дараах ашиг/алдагдал** | | **сая.төг** | **(2,544.3)** | **(2,700.8)** | **(2,218.4)** | **446.9** | **83%** | **482.3** | **82%** |
| 6 | Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал | | төг | 1.7 | 1.6 | 1.5 | (0.1) | 92% | (0.0) | 98% |
| 7 | **Нийт авлага** | | **сая.төг** | **235.3** | **165.0** | **603.0** | 367.8 | 256% | 438.0 | 365% |
| | Үүнээс: | Борлуулалтын авлага | сая.төг | 191.0 | 165.0 | 594.1 | 403.0 | 311% | 429.1 | 360% |
| | | Бусад | сая.төг | 44.3 | | 9.0 | (35.3) | 20% | 9.0 | 0% |
| 8 | **Нийт өглөг** | | **сая.төг** | **3,966.6** | **4,632.4** | **6,165.9** | 2,181.9 | 155% | 1,533.5 | 133% |
| | Үүнээс: | Урт хугацаат өр төлбөр | сая.төг | | | | (17.4) | 0% | - | 0% |
| | | Богино хугацаат өр төлбөр | сая.төг | 3,966.6 | 4,632.4 | 6,165.9 | 2,199.3 | 155% | 1,533.5 | 133% |
| 9 | **Нийт ажиллагсдын тоо** | | **тоо** | **140.0** | **140.0** | **140.0** | **-** | **100%** | **-** | **100%** |
| 10 | Нийт цалингийн сан | | сая.төг | 2,652.2 | 3,394.0 | 3,357.4 | 632.4 | 123% | (36.6) | 99% |
| 11 | Нэг сарын дундаж цалин | Нийт ажиллагсдын | сая.төг | 1.62 | 1.95 | 1.93 | 0.306 | 119% | (0.022) | 99% |
| | | Удирдлагын | сая.төг | 3.19 | 3.55 | 3.33 | 0.134 | 104% | (0.219) | 94% |
| | | ИТА-ын | сая.төг | 2.31 | 2.89 | 2.57 | 0.259 | 111% | (0.319) | 89% |
| | | Ажилчдын | сая.төг | 1.31 | 1.77 | 1.79 | 0.477 | 136% | 0.023 | 101% |
| 12 | Жишмэл түлшний хувийн зарцуулалт | цахилгаан | гр/кВтц | 31.3 | 38.4 | 34.4 | 3.1 | 110% | (4.067) | 89% |
| | | дулаан | кг/Гкал | 224.1 | 193.6 | 198.8 | (25.3) | 89% | 5.203 | 103% |
| 13 | Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт | | сая.төг | 555.2 | 842.5 | 838.5 | 744.9 | 900% | (4.442) | 99% |
| | Үүнээс: | Их засвар | сая.төг | 162.9 | 291.6 | 290.9 | 284.4 | 4476% | (0.689) | 100% |
| | | ТЗБАХ | сая.төг | 98.3 | 205.1 | 204.2 | 179.3 | 820% | (0.899) | 100% |
| | | Хөрөнгө оруулалт | сая.төг | 294.0 | 345.7 | 343.4 | 281.2 | 556% | (2.853) | 99% |

**Гурав. Аудитын илрүүлэлт:** Аудитаар нийт 87,181.8мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулж, нийт Аудитаар 5,192.0мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 146,785.2мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өгсөн.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Багануур дулааны станц ТӨХК | 1 | 87,181.8 | | | 1 | 87,181.8 | 1 | 87,181.8 | | | | |
| **Дүн** | 1 | 87,181.8 | | | 1 | 87,181.8 | 1 | 87,181.8 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Багануур дулааны станц ТӨХК | 10 | 309,389.9 | 2 | 5,192.0 | 1 | 146,785.2 | 7 | 157,412.7 | - | - | - | - |
| **Дүн** | **10** | **309,389.9** | **2** | **5,192.0** | **1** | **146,785.2** | **7** | **157,412.7** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Багануур дулааны станц ТӨХК | 3 | 2,093,605.7 | - | - | 1 | 2,093,605.7 | 2 | - |
| **Дүн** | **3** | **2,093,605.7** | **-** | **-** | **1** | **2,093,605.7** | **2** | **-** |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | Аудитад хамрагдах | Санал дүгнэлт гаргасан | Түвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалт тай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | | 1 | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | | **1** | | |